



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,  
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2018.05.22 № 33

Асуулт тавих тухай

Ханшийн өсөлттэй байсан үеийг бодвол тогтворжоод байсан ам.долларын ханш өнгөрсөн өдрүүдэд огцом өсөж, валютын зах дээр арилжиж буй нэг ам.долларын ханш 2475 төгрөгт хүрээд байна.


Цаг агаар дулаарч бүтээн байгуулалтын болон бусад ажил сэргэж буй энэ цаг үед ам.долларын эрэлт улам нэмэгдэх тул ам.долларын ханшны өсөлтийн шалтгааныг тодруулж, өсөлтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж буй эсэх талаар Монголбанкны байр суурийг тодруулах үүднээс дараах асуултыг тавьж байна. Үүнд:

- Ам.долларын ханш огцом өсөхөд нөлөөлсөн гол шалтгаан юу вэ ?
- Ам.долларын ханш өссөнөөр улсын төсөвт нэмэгдэж ирэх ачааллын талаар :
- Ам.долларын ханш өссөнөөр иргэд, аж ахуйн нэгж байгууллагад нэмэгдэж ирэх ачааллын талаар :
- Ам.долларын ханшийн одоогийн байдлыг богино хугацаанд яаж зохицуулах гэж байна вэ?
- Ам.долларын нийлүүлэлт буюу орох урсгалыг нэмэгдүүлэх тал дээр авч хэрэгжүүлж буй тодорхой арга хэмжээ?

Ам.долларын ханшийн өсөлтийг даруй барьж, тогтвортой байлгах тал дээр байр сууриа яаралтай тодорхойлж, нийгэмд зөв мэдээллийг өгөхгүй бол зах зээл дээр ханшийн савлагаа үүсэж, буцаад тогтохдоо өнөөдрийн ханшнаас өндөрт ирж тогтдог сөрөг үр дагавартай байгаа билээ.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэгт зааснаар 14 хоногийн хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Байнгын хорооны хуралдаанд сонгохыг танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



О.БАТНАСАН